UKaid from the British people | ZSL LET'S WORK FOR WILDLIFE | STEPPE FORWARD PROGRAMME | Магадлан итгэмжлэл Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл

БАЙГАЛИЙН БАЯЛАГАА ЗӨВ АШИГЛАЯ

ИРГЭН БҮР МЭДДЭГ, МӨРДДӨГ БАЙХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА | УЛААНБААТАР ХОТ 2018 ОН

ГАРЧИГ

ЗОРИЛГО....4
ӨМНӨХ ҮГ....4
МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ТОГТОЛЦОО....6
МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨРИЙН ТОГТОЛЦОО....7
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТ (НӨХӨРЛӨЛ)....14
ИРГЭН ТА БАЙГАЛЫН БАЯЛГИЙГ АШИГЛАХ ЭРХТЭЙ....18
Агнах, барих ан амьтны зохицуулалт (Амьтны тухай хуулиас):....18
Агнуурын амьтан агнах, барихтай холбогдох хориглосон үйл ажиллагаа:....18
Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, загас барих эрхийн бичиг....22
Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа....23
Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ....25
Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах....33
Нөхөн төлбөр....36
ХАРИУЦЛАГА....37
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгээс)....40
ГАЛТ ЗЭВСГИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДАЛ....42

ЗОРИЛГО

Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн хэрэгжүүлж буй “Хуулийн хэрэгжилтийг сайжруулснаар зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах нь” төслийн хүрээнд иргэдийн байгаль хамгаалал, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр Төрийн байгууллагын тогтолцоо болон хууль эрх зүйн тогтолцоон дахь ИРГЭН-ний эрх, үүрэг, давуу талын ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсрууллаа.

ӨМНӨХ ҮГ

Манай ард түмэн олон зууны тэртээгээс байгаль дэлхийгээ шүтэж, хайрлан хамгаалж ирсэн сайхан уламжилтай билээ. Бөөгийн шашны үед тэнгэр эцэг, газар эх хэмээн өргөмжилж тэнгэрийг нар, сар, од гаригийн эрхшээлтэй нь хамт, газрыг хөрс шороо ургамал, уул, ус, амьтантай нь цогц байдлаар хүндлэн биширч, хүн ардаа төлөвшүүлэн иржээ. Бурхны шашины үед Монголчуудын байгаль хамгаалах уламжлалыг өөрийн сургаал номлолоор зохицуулсан шүтэн барилдах, орчин үеийн дэлхийн шинжлэх ухааны экологи хэмээх ухагдахууныг бүрэн гаргаж ирсэн гэж үзэж болох юм.

Монголчуудын байгаль хамгаалах уламжлал нь бидний өвөг дээдэс болох Хүннүгээс эхтэй гэж үзэх болох талтай бөгөөд МЭӨ-209 онд Маодунь Шаньюй “Газар бол улсын үндэс” хэмээн үзэж байсан бол дараа дараагийн гарч ирсэн улсууд нь байгаль хамгаалах тал дээр анхаарч тахилга тайлга үйлдэж байсан мэдээ байна .

1206 онд Их Монгол улс байгуулагдсанаар байгаль хамгаалах хууль цаазын нэгдмэл тогтолцоо бий болж энэ үеийн гол хууль нь ”Их засаг хууль” юм. Их Засаг хуульд эх болсон байгалиа хамгаалах нарийн заалтууд бий. Монголчуудын байгаль хамгаалах уламжлал нь Их Юан гүрний үед “Их Юаний хууль цаазын бичиг”-т улам гүнзгийрүүлэн хөгжиж улмаар байгаль

хамгаалалтай холбоотой олон хууль тогтоомжууд гарч байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж ирсэн байна.

2012 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Байгаль орчин ба тогтвортой хөгжил" бага хурлаас байгальд ээлтэй үйлдвэрлэл, нийгмийн хандлага, ёс зүйг төлөвшүүлж тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх арга зам нь ногоон эдийн засгийн хөгжил гэж тодорхойлсон билээ.

Сүүлийн үед тогтвортой хөгжлийг хангах, байгаль хамгаалах үйл ажиллагаанд байгалийн нөөцийн хамтын менежмент гэдэг ойлголт чухлаар тавигдаж байгаа билээ. Монгол Улсын Их Хурлаас 2005, 2012 онд "Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох тухай хууль"-д бодлогын шинжтэй шинэчлэл хийгдснээр төр, засгийн хяналт шалгалт, зөвшөөрлийн системээр хэрэгждэг бодлогоос хамтын оролцооны арга хэлбэрт шилжих, төвлөрлийг сааруулах, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэхэд нь нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий хамтын менежментийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндэс бий болсон юм.

Орон нутгийн ард иргэд өөрсдийн хүсэл зорилгоор нэгдэн нийлж, нөхөрлөл байгуулж, байгаль хамгаалах хөтөлбөр болон менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэний зэрэгцээ байгалийн тодорхой төрлийн баялгийг нөхөрлөлийн зүгээс ашиглах, эзэмших давуу эрхтэй болсон билээ. Энэхүү өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд байгаль хамгаалах уламжлалт арга хэлбэрийг шинэ үзэл санаатай хослуулан нэг байгаль хамгаалагчийн тогтолцооноос нийт иргэдийн оролцоотой байгаль хамгааллын тогтолцоонд шилжиж эхлээд байна. Иргэн бүр хуулиа мэддэг, эрхээ эдэлдэг, үүргээ биелүүлдэг байх нь Байгалийн баялгаа зохистой ашигладаг, хамгаалдаг, нөхөн сэргээдэг байхын гол ҮНДЭС юм.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ТОГТОЛЦОО

Монгол улсын ҮНДСЭН ХУУЛЬ:

Монгол улсын ИРГЭНИЙ ЭРХ:

Монгол улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

Байгалийн баялаг:

Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч юм.

Байгаль орчныг

Хамгаалах тухай хууль:

Энэ хууль нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондын харилцааг зохицуулна.

Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

1/гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;

4/холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/байгалийн нөөц, баялгийн

халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;

6/сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших.

2.Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;

3/байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх.

4/байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль:

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөр, хураамжид байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгосны хураамж, нөөц ашигласны төлбөр, зөвшөөрсөн хэмжээнд хог хаягдал, бохирдуулах бодис гаргасны төлбөр хамаарна.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨРИЙН ТОГТОЛЦОО

Улсын Их хурал:

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. УИХ нь Монгол улсын байгалийн баялагийн ашиглалт хамгаалалттай холбоотой хууль тогтоомжийг баталдаг.

Шүүх:

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан гэмт хэрэг, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч болон шүүх бүрэлдэхүүнийг “Шүүх” гэдэг. Шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан байх бөгөөд

шүүх эрх мэдлийг аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна.

Прокурор:

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцдог.

Засгийн газар:

Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүрэг нь

- Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах.

- Байгалийн баялгийг судалж нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

- Газар, түүний хэвлий, ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- Дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горим, дурсгалт болон нөөц газрын хилийн зааг, хамгаалалтын горим тогтоож, биелэлтийг нь зохион байгуулна.

Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ:

Эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

Улс орны тогтвортой хөгжилд нийцсэн байгаль орчин, ногоон

хөгжил, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр боловсруулж батлуулах, бодлогын удирдамжаар хангах, түүнийг дэмжсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, цэвэр технологийг дэмжих, салбарын санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалтаар хангах;

Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, байгаль орчны сайн засаглалыг бэхжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоо, хяналтад тулгуурлан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

Ойн экосистемийн тэнцвэрийг хадгалах, нөөцийн хомсдолыг хязгаарлан зогсоох, ойн санг арвижуулах, нөөцийг иж бүрэн ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох, ойн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

Усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах, газар зохион байгуулалт болон усны талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

Аялал жуулчлалын талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх;

Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэл, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэлт, зөвлөмж гаргах, үнэлгээний талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах.

Мэргэжлийн хяналтын газар:

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих яналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч тус тус ажиллана.

Монгол улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрхэм зорилго оршино.

Байгаль орчны бүхий л хууль тогтоомж, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгөх үүрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газар:

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага юм.

Байгаль орчныг бохирдуулах, Хууль бусаар ан агнах, Хууль бусаар мод бэлтгэх, Ой, хээрийн түймэр тавих, Байгалын ургамлыг хууль бусаар бэлтгэх зэрэг Эрүүгийн хуульд заасан “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг”-ийг мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна.

Аймаг, Нийслэлийн ИТХ:

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавина. Мөн нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн

дээд хэмжээг тогтоож, байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авна.

Хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчинг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоож, байгаль орчны төлөв байдал, мэдээллийн сангийн тухай Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэнэ.

Аймаг, Нийслэлийн Засаг дарга

Аймаг, Нийслэлийн Засаг дарга нь байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах үүрэгтэй.

Нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

Мөн нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд дэмжин хөгжүүлэх мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

Сум, Дүүргийн ИТХ:

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

2/нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн хэмжээг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тогтоох

Баг, хорооны иргэдийн нийтийн хурал:

Баг, хорооны иргэдийн нийтийн хурал нь эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах, нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих эрхтэй. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсож, нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Баг, хорооны Засаг дарга:

Байгаль орчныг хамгаалах талаархи хууль тогтоомж, иргэдийн Нийтийн Хурал болон дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан

оролцуулна. Мөн нутаг дэвсгэртээ орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах, нийтийн хог хаягдлын цэг тогтоож, нөхөрлөл байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлнэ.

Байгаль орчны хяналтын Улсын байцаагч:

Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.

Улсын байцаагч дараахь эрхтэй байна:

• хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагаа нь түр зогсоох;

• хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;

• байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

• байгаль орчныг хамгаалах тухайхуультогтоомжийнхэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;

• Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах;

2.Улсын байцаагч дараахь үүрэгтэй байна:

• байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

• илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

• байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

Цагдаа:

Цагдаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах Төрийн тусгай албан хаагч юм.

Байгаль хамгаалагч:

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий

сургуулийн мэргэжлийн сургалтанд хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна.

• хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

• хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

• иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих;

Идэвхтэн байгаль хамгаалагч:

Тухайн орон нутагт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг хэрэгжүүлэхэд туслах үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж болно.

“Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах журам” БОНХАЖ-ын сайдын 2015 оны 2 сарын 26-ний А-110 тоот тушаалаар баталсан.

Идэвхтэн байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор дараах үйл ажиллагаа явуулна:

1. иргэдийн ан агнах, байгалийн нөөц баялгийг ашиглах зөвшөөрөл, төлбөр, хураамж төлсөн эсэхийг шалгаж, ашиглалт явуулах газар нутгийг зааж өгөх;

2. зохих зөвшөөрөлгүй буюу төлбөр, хураамжаа төлөөгүй иргэдийн ан агнах, байгалийн нөөц баялаг ашиглах үйл ажиллагааг нь зогсоож, тухайн нутгаас гарч явахыг шаардах;

3. байгалийн нөөц баялгийг хууль бусаар ашигласан, агнасан, олборлосон үйлдэлд акт бичиж баримтжуулах;

4. байгалийн нөөц баялгийг хууль бусаар ашигласан, агнасан, олборлосон тухай мэдээллийг нэн даруй хүргүүлэх;

5. ой, хээрийн түймэр. үер, усны аюул зэрэг гамшиг тохиолдох үед тэр тухай мэдээллийг цаг алдалгүй дамжуулах, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай авах;

6. хариуцсан нутаг дэвсгэрийнхээ нөөц баялгийг иргэд ахуйн хэрэгцээндээ хэрэглэх тохиолдолд түүний газар нутаг, хил хязгаарыг зааж өгөх, зөвлөгөө өгөх;

Байгалийн нөөц баялгийг хууль бусаар бэлтгэсэн, агнасан, түүсэн тухай мэдээлсэн, зөрчлийг илрүүлж учруулсан хохирол, нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэхэд идэвх зүтгэл гарган ажилласан бол идэвхтэн байгаль хамгаалагчийг тухайн зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн 15 хувиар тус тус шагнаж урамшуулна.

Иргэн (Үндсэн хуулиас):

Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

4/ эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2. хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг юм.

Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТ (НӨХӨРЛӨЛ)

Нутгийн иргэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож түүнээс нийгэм эдийн засгийн ашиг тус хүртэж байх үйл явцыг байгалын нөөцийн хамтын менежмент гэнэ.

Нөхөрлөлийн гишүүн хэн байх вэ.

18 нас хүрсэн, тухайн нутагтаа байнга оршин суугч Монгол Улсын иргэн байна.

Байгалийн нөөцийн хамтын менежментийн хамрах хүрээ

Газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан агаар, соёлын өвд хамрагдах газар.

Иргэдийн нөхөрлөл байгуулах хууль зүйн үндэс

Монгол улсын Үндсэн хууль болон Байгаль орчныг хамгаалах хуулиар иргэдэд хэд хэдэн төрлийн эрхүүд олгогдсон байдаг. Эдгээр эрх нь улс орны урт хугацааны сайн сайхан байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах үндэс суурийг бий болгоно. Доор Монгол Улсын Байгаль Орчныг Хамгаалах Тухай Хуульд заасан Монгол улсын иргэний эрхийг тусгасан болно. Үүнд:

- Иргэн байгаль орчныг хамгаалах төрийн бус байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх эрхтэй. Мөн нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх эрхтэй. Хуулинд өөрөөр заагаагүй бол Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд нь байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.
- Төр түүний байгууллага, албан тушаалтан нь нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн баялгийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг хариуцуулах хэлбэрээр байгаль орчныг хамгаална.
- Иргэдийн нөхөрлөл байгуулах эрх нь Байгаль Орчныг Хамгаалах Тухай Хуульд зааснаас гадна бусад хуулиудаар бас олгогдсон байна. Орон нутгийн иргэд уул уурхайтай холбогдолтой шийдвэрт оролцох, уурхайн үйл ажиллагаар хянах эрхүүдээр мөн хангагдсан. Иргэдийн нөхөрлөл нь үйл ажиллагаагаа Байгаль Орчны Сайдын 2006 оны 4 сарын 26-ны өдрийн 114 тушаалын хавсралт журмын дагуу явуулна.

Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нөхөрлөл нь бүх гишүүдийн хурлаар баталсан менежментийн төлөвлөгөөтэй байна.

Менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана

- Хариуцаж байгаа байгалийн нөөц, баялгийн мэдээлэл, нутаг дэвсгэрийн хил хязгаарыг баталгаажуулсан зураг,
- Байгалийн нөөцийн хамтын менежмент явуулах нөхөрлөлийн ашиглах байгалийн нөөцийн тархацын хил хязгаар, тоо хэмжээ, даац, чанар г.м,
- Тухайн төрлийн байгалийн нөөцөд онцлог шинж чанар т тохирсон менежмент явуулах арга, хэлбэр,
- Нөхөрлөлийг ашиглаж, эзэмшиж байгаа байгалийн нөөцийн төлөв байдлыг хянах шинжилгээний хөтөлбөр,
- Гишүүдийн үүрэг болон хамтрагч талуудтай хамтрах ажил,
- Санхүүгийн төлөвлөгөө,
- Бүх гишүүдийн хурлаас тогтоосон бусад зүйлс.

Нөхөрлөлийн үйл ажиллагааны тайлан

Нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийн тухай тайланг жил бүр тухайн сум, дүүрэг, баг хорооны, Хуралд тайлагнах бөгөөд үүнд баялгийг

хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, нөөц баялгийн төлөв байдал, түүний өөрчлөлтийг тусгана.

Нөхөрлөлийн эрх үүрэг

• Нөхөрлөл нь гэрээний үндсэн дээр хамтын менежмент ээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах эрхтэй.

• Нөхөрлөл нь өөрийн эзэмшлийн газар болон байгалийн нөөц бусад эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

• Нөхөрлөл нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банканд данстай байж болно.

Нөхөрлөлтэй байгуулсан гэрээ ямар нөхцөлд цуцлах вэ

Дараах нөхцөлд тухайн сум, дүүргийн Засаг дарга гэрээг цуцална.

• Хорооны иргэдийн Нийтийн хурлын санал

• Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр,

• Гишүүдийн хурлаар үйл ажиллагааг зогсоох шийдвэр,

• Байгаль орчныг хамгаалах хуулийн шаардлагыг хангаагүй,

Төрийн захиргааны байгууллагуудын дэмжлэг

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааний төв байгууллага

• Менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн зөвлөгөө өгөх

• Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэгдсэн удирдлагаар хангах

Аймаг нийслэлийн Засаг дарга

• Нөхөрлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэгтэй төсөв баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

• Мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах

• Тухайн жилд нөхөрлөлийн хэрэгжүүлсэн тайланг иргэдийн Төлөөлөлгчдийн Хуралд хэлэлцүүлэх

• Байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах.

Сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

• Нөхөрлөлд хариуцсан асуудлыг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн шийдэх.

• Нөхөрлөлийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах, хянах

Сум дүүргийн Засаг дарга

• Иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж хяналт тавих.

• Байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах, халдашгүй байдлыг нь хангах тухайн нутаг дэвсгэрээ хариуцах.

• Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн сургалт явуулж үд дүнг сумын иргэдийн Нийтийн хуралд тайлагнах.

Баг хорооны иргэдийн нийтийн хурал

• Нөхөрлөл байгуулах талаар багийн Засаг даргаас ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэх

Баг хорооны Засаг дарга

• Нөхөрлөлийг байгуулах болон түүний үйл ажиллагаатай холбогдсон саналыг иргэдийн нийтийн Хуралд танилцуулж хэлэлцүүлэх.

Нөхөрлөл түүний давуу тал

• Нөхөрлөлийн гишүүд зохих журмын дагуу өмчилсөн болон эзэмшсэн газар дээрээ өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан ой мод ургамал жимс өсгөж үржүүлсэн ан амьтан, загас, бороо, цасны усыг хуримтлуулан өөрийн хөрөнгөөр бий болгосон юсан сан, нуур, цөөрөм өмчилж авах эрхтэй.

• Нөхөрлөл үржүүлсэн амьтан, тарьж ургуулсан мод ургамал, засаж тохижуулсан газар, сэргээн засварласан усны ундрага, зэргийг зохих урамшуулал авах буюу төрд худалдаж болно.

• Бэлчээрийн даац, малын тоо толгойг уялдуулан, бэлчээрээ сэлгэж ашиглах уламжлалыг сэргээн бэлчээрийн чанарыг сайжруулна.

• Хүмүүсийн мэргэжил, ур чадварыг уялдуулан хөдөлмөрийн хуваарьтайгаар ашиглана.

• Хэт жижгэрсэн, тархай бутархай амиа аргацаасан үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг халж, шинэлэг хамтач зохион байгуулалтыг нэвтрүүлнэ.

• Шинэ ба залуу малчдыг туршлагатай, чадвартай малчдыг

дагалдуулан сургах

• Эрх ашиг нь хөндөгдсөн аливаа асуудалд идэвхтэй оролцож, эрх ашгаа хамгаалах малчдын нийгмийн идэвх, боломж дээшилнэ.

• Хөдөлмөр ихээхэн шаарддаг мал аж ахуй үйлдвэрлэлд хөдөлмөрөө хорших замаар илүүдэл ажиллах хүчийг мал аж ахуйгаас аажмаар чөлөөлөх бололцоо нэмэгдэнэ.

ИРГЭН ТА БАЙГАЛЫН БАЯЛГИЙГ АШИГЛАХ ЭРХТЭЙ

Агнах, барих ан амьтны зохицуулалт (Амьтны тухай хуулиас):

Амьтны тухай хууль нь 2012 онд шинэчлэн батлагдсан.
Амьтныг хамгаалах, өсгөж үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.

Иргэн болон хуулийн этгээд агнуурын амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, ангийн гаралтай түүхий эд бэлтгэх зорилгоор агнуурын бүс нутгийн тодорхой хэсгийг гэрээний дагуу эзэмшиж болно.

Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон анчны үнэмлэхтэй иргэнийг “анчин” гэнэ. Агнуурын амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар мэдлэгтэй, ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэнд “анчны үнэмлэх” авах эрхтэй.

Агнуурын амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл

• химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;

• агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих;

• туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих;

• тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах;

• агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх;

• загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх;

• ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх;

• ан агнах зориулалтын бус буу, сумаар;

• гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах.

Агнуурын амьтан агнах, барихтай холбогдох хориглосон үйл ажиллагаа:

• шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих;

• булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах;

• өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих;

• агнуурын амьтны үүр, ичээ ухах, гэмтээх;

• агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий

байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах;

• агнуурын амьтныг сайн танилгүй буюу анир чимээнээр таамаглаж буудах;

• агнуурын амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах;

• ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх;

• тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах;

• хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомт эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих;

• үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих бүх төрлийн торны нүдний хэмжээ 50х50 мм-ээс доош байх;

Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах

Сум, дүүргийн Засаг дарга тухайн жилд агнах агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгоно.

Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих

Иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно.

Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана.

Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийн хугацаа:

• шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног;

• бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоног.

Иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна.

Дараах схемээр жишээ болгон ахуйн зориулалтаар ан хийхэд шаардагдах зүйлсыг оруулав.

АХУЙН ЗОРИУЛАЛТААР АН ХИЙХЭД ШААРДЛАГАТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДАРААХ СХЕМЭЭР ЖИШЭЭ БОЛГОН ХАРУУЛАВ.

1. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн *төрийн захиргааны байгууллагаас* анчны үнэмлэх авах)

↓

2. Ангийн буу аюулгүй байдал хангасан бүртгэлтэй байх,

↓

3. Сумийн *Засаг даргад* ахуйн зориулалтаар ан хийх хүсэлт гаргах

↓

4. Төлбөр, хураамжаа төлөх

↓

5. Ангийн төлбөр, хураамж төлсний дараа эрхийн бичиг (зөвшөөрөл) авна. (эрхийн бичигт агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заасан байна).

↓

6. Зөвшөөрлийн дагуу ан хийх

↓

7. Тухайн сум дахь *байгаль хамгаалагчаас* гарал үүслийн тодорхойлолт авах шаардлагатай.(жишээ нь гарал үүслийн бичиг авснаар тээвэрлэх явцад хяналт шалгалт хийж буй мэргэжилтэнд хаанаас, хичээн тооны ямар амьтан агнасан зэрэгийг үзүүлж хуулийн дагуу агнасан гэдгийг нотох баримт болох юм)

Жишээ нь Ойн зэрлэг гахайг агнах бол:

1. Зэрлэг гахайг агнахыг хориглосон хугацаа нь 12 сарын 1-ээс 8 сарын 31 хүртэл байдаг ба бусад хугацаанд Засаг даргад хүсэлт гаргах.
2. Засаг дарга зөвшөөрөл олгосон тохиолдолд зөвшөөрлийн хураамж эр зэрлэг гахайд 140 000 төг эм зэрлэг гахайд 160 000 төг тушаана.
3. Хэрэв та зөвшөөрөлгүй агнасан тохиолдол зэрлэг гахайн экологи эдийн засгийн үнэлгээгээр эр нь 700 000 төг, эм нь 800 000 төг байдаг ба үүнийг 2 дахин нугалж төлөх ба Зөрчлийн хуулийн дагуу 150.000 төгрөгийн торгууль төлнө.

АНХААР !!!

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн бол ЭРҮҮГИЙН ХУУЛЬ-аар хариуцлага хүлээнэ.

Ахуйн зориулалтаар ан амьтан агнах, загас барих эрхийн бичиг

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/75 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

АХУЙН ЗОРИУЛАЛТААР АН АМЬТАН АГНАХ, ЗАГАС БАРИХ ЭРХИЙН БИЧИГ

.......оны.......р сарын.......ны өдөр

№ 0019400

....

....
/оршин суудаг газрын хаяг/

....-д
/овог, нэр, регистрийн дугаар/

....
/сум, дүүрэг, газрын нэр/

....

....-ийг
/ан амьтны нэр тоо, үсгээр/

....оны....р сарын....-ны өдрөөс....оны....р сарын....-ны өдрийг дуустал /..../ хоногийн хугацаанд агнах, барих эрхийн бичиг олгов.

Хураамжинд.........................төгрөг хураав.

Хугацаа дуусмагц хүчингүй.

Тамга

ЭРХИЙН БИЧИГ Олгосон ....
/албан тушаал, овог, нэр/

....
/гарын үсэг/

Хүлээн авсан ....
/гарын үсэг/

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн сум дахь байгаль хамгаалагчаас гарал үүслийн тодорхойлолт авах шаардлагатай.

Гарал үүслийн бичиг

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/75 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАРАЛ ҮҮСЛИЙН БИЧИГ

Сери .... Дугаар 0017800

Аймаг.................................... Сум ....

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэгчийн нэр, хаяг ....

....

Ан амьтны тоо хэмжээ ....

Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бэлтгэх эрхийн бичиг эсхүл гэрээний дугаар ....

Түүхий эдийн нэр, төрөл: ....

Олгосон он.................... сар.................... өдөр ....

Хүчинтэй хугацаа .... сар

Олгосон
/тамга/

....
/Гарал үүслийн бичиг олгосон улсын байцаагчийн овог нэр, тамга, гарын үсэг/

АГНУУРЫН АМЬТАН АГНАХ, БАРИХЫГ ХОРИГЛОХ ХУГАЦАА

Агнуурын амьтныг дор дурдсан хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглоно:

	АМЬТНЫ НЭР ТӨРӨЛ	АГНАХЫГ ХОРИГЛОСОН ХУГАЦАА (Жил бүрийн)
1	Бор гөрөөс, цагаан зээр, зэрлэг гахай	12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл
2	Ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, ойн солонго, усны булга, өмхий хүрэн, мануул мий, хотны үен, цагаан үен, чандага туулай, бор туулай	02 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл
3	Урт сүүлт зурам, тарвага	10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл
4	Заарт харх	02 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл
5	Халздай дорго	11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл
Ахуйн болон тусгай зориулалтаар дор дурдсан хугацаанд шувуу агнах, загас барихыг хориглоно:		
6	шивэр хөтүү, дагуур ятуу, эрээнхавирга хахилаг, говийн ногтруу, хар хур, эгэл сойр	3 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;
7	галуу, нугас болон ус, намгийн бусад агнуурын шувуу	4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;
8	дархадын цагаан загас	8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл
9	Буйр нуурын загас	Буйр нуурын загас
10	Угалз	10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл

11	Тэх	10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 14-ний өдөр хүртэл
12	Хар сүүлтийн зээрийн оон	11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл
13	Халиун буга	9 дүгээр сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл.
14	Аргаль хонь, янгир ямаа	10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл
15	Хар сүүлтийн зээр	10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;
16	Идлэг шонхор шувуу	11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;
17	Цармын бүргэд	11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;
18	Тул загас	10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

- Ахуй, үйлдвэрлэл, соёл шинжлэх ухааны зориулалтаар агнасан ан амьтны төлбөрийг тухайн амьтны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээний 20-40%-иар тогтооно

АН АМЬТНЫ ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

ЗГ-ын 2011 оны 23-р тогтоолын нэгдүгээр хавсралт (хэсэгчлэн авав)

Нэг.Хөхтөн **/мян.төгрөгөөр/**

№	АМЬТНЫ НЭР	ЛАТИН НЭР	Экологи-эдийн засгийн үнэлгээ	
			эр	эм
		I. Туруутан		
1	Халиун буга	Cervus elaphus	6600.00	7500.00
2	Хүдэр	Moschus moschiferus	3000.00	3500.00
3	Шивэр хандгай Мөрний хандгай	Alces alces pfizenmayeri Alces alces cameloides	10000.00	12000.00
4	Аргаль хонь	Ovis ammon	11000.00	13000.00
5	Янгир ямаа	Capra sibirica	2700.00	3100.00
6	Бор гөрөөс	Capreolus pygargus	330.00	400.00
7	Цаа буга	Rangifer tarandus valentinae	5000.00	6000.00
8	Цагаан зээр	Procapra gutturosa	500.00	550.00
9	Хар сүүлтий	Gazella subgutturosa	1700.00	2000.00
10	Монгол бөхөн Соргог бөхөн	Saiga tatarica mongolica Saiga tatarica tatarica	2000.00	2200.00
11	Ойн зэрлэг гахай	Sus scrofa sibiricus	700.00	800.00
12	Зэгсний зэрлэг гахай	Sus scrofa nigripes	2900.00	3300.00
		II.Туурайтан		
13	Хулан адуу	Equus hemionus	9700.00	11000.00
14	Тахь	Equus przewalski	11000.00	13000.00
		III.Саарьтан		
15	Хавтгай	Camelus bactrianus ferus	19000.00	21300.00

IV.Махчтан				
16	Саарал чоно	Canis lupus	510.00	600.00
17	Шар үнэг	Vulpes vulpes	110.00	130.00
18	Хярс үнэг	Vulpes corsac	100.00	120.00
19	Нохой элбинх	Nyctereutes procyonoides	260.00	300.00
20	Хүрэн баавгай	Ursus arctos	6500.00	7500.00
21	Мазаалай	Ursus arctos gobiensis	19000.00	22000.00
22	Ойн булга	Martes zibellina	450.00	510.00
23	Суусар булга	Martes foina	470.00	530.00
24	Нохой зээх	Gulo gulo	730.00	840.00
25	Ойн үен	Mustela sibirica	23.00	26.00
26	Солонго үен	Mustela altaica	21.00	24.00
27	Цагаан үен	Mustela erminea	21.00	24.00
28	Хотны үен	Mustela nivalis	21.00	24.00
29	Хүрэн үен	Mustela eversmanni	21.00	24.00
30	Усны үен	Mustela vison	25.00	30.00
31	Эрээн хүрнэ	Vormela peregusna	60.00	70.00
32	Халздай дорго	Meles meles	510.00	600.00
33	Голын халиу	Lutra lutra	2400.00	2700.00
34	Цоохор ирвэс	Uncia uncia	11200.00	13000.00
35	Шүлүүс мий	Lynx lynx	2300.00	2600.00
36	Говийн шүлүүс мий	Lynx lynx isabellina	2600.00	3000.00

37	Мануул мий	Otocolobus manul	440.00	500.00
38	Цоохондой мий	Felis silvestris	850.00	950.00
V.Туулайтан				
39	Бор туулай	Lepus tolai	35.00	40.00
40	Чандага туулай	Lepus timidus	40.00	45.00
VI.Мэрэгчтэн				
41	Бараан хэрэм	Sciurus vulgaris	32.00	36.00
42	Замба жирх	Tamias sibiricus	4.00	5.00
43	Алтайн тарвага	Marmota baibacina	180.00	210.00
44	Монгол тарвага	Marmota sibirica	170.00	200.00
45	Төв азийн минж	Castor fiber birulai	1300.00	1500.00
46	Заарт ондоотор	Ondatra zibethicus	120.00	130.00

Хоёр. Шувуу **/мян.төгрөгөөр/**

№	ШУВУУНЫ НЭР	ШУВУУНЫ ЛАТИН НЭР	ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ
I. Усны шувуу			
1	Улаангүеэ гахуун	Gavia stellata	30.00
2	Хилэнгүеэ гахуун	Gavia arctica	37.00
3	Халтар шунгуур	Podiceps nigricollis	7.00
4	Ухаа шунгуур	Podiceps auritus	8.00
5	Буурал шунгуур	Podiceps grisegena	12.00
6	Отгот шунгуур	Podiceps cristatus	18.00
7	Хурган шунгуур	Podiceps ruficollis	5.00
8	Борцгор хотон	Pelecanus crispus	6570.00

9	Тураг гогой	Phalacrocorax carbo	31.00
10	Усны бухшувуу	Botaurus stellaris	18.00
11	Бичил одойбух	Ixobrychus minitus	5.00
12	Бөртөт одойбух	Ixobrychus eurhythmus	5.00
13	Цагаан дэвлээ	Ardeola bacchus	9.00
14	Ногоовор зашин	Nycticorax nycticorax	14.00
15	Цасч тэглэй	Egretta alba	25.00
16	Хурган тэглэй	Egretta garzetta	10.00
17	Хөх дэглий	Ardea cinerea	19.00
18	Зээрд дэглий	Ardea purpurea	25.00
19	Цагаан халбагант	Platalea leucorodia	110.00
20	Дорнын өрөвтас	Ciconia boyciana	380.00
21	Хар өрөвтас	Ciconia nigra	204.00
22	Ягаан нал	Phoenicopterus roseus	84.00
23	Бор галуу	Anser anser	58.00
24	Буурал галуу	Anser fabalis	61.00
25	Манхин галуу	Anser albifrons	77.00
26	Одой галуу	Anser erythropus	119.00
27	Хээрийн галуу	Anser indicus	110.00
28	Хошуу галуу	Anser cygnoides	211.00
29	Гангар хун	Cygnus cygnus	376.00
30	Хуруут хун	Cygnus olor	480.00
31	Гунгар хун	Cygnus bewickii	125.00
32	Модны анхир	Dendrocygna javanica	27.00
33	Хондон ангир	Tadorna ferruginea	17.00
34	Анхидал ангир	Tadorna tadorna	20.00

35	Зэрлэг нугас	Anas platyrhynchos	23.00
36	Зэрлэгшир нугас	Anas poecilorhynchos	20.00
37	Ногоохон нугас	Anas crecca	7.00
38	Байгалийн нугас	Anas formosa	143.00
39	Гэзэгт нугас	Anas falcata	13.00
40	Бор нугас	Anas strepera	16.00
41	Зээрд нугас	Anas penelope	13.00
42	Шовтгоралаг нугас	Anas acuta	16.00
43	Цагаанхөмсөгт нугас	Anas guerguedula	9.00
44	Халбага нугас	Anas clypeata	15.00
45	Мандир уранхажин	Aix galericulata	30.00
46	Улаанхушуу биваан	Netta rufina	15.00
47	Улаанхүзүү шумбуур	Aythya ferina	16.00
48	Ундар шумбуур	Aythya nyroca	12.00
49	Ухаа шумбуур	Aythya baeri	50.00
50	Гэзэгт шумбуур	Aythya fuligula	17.00
51	Тэнгисийн шумбуур	Aythya marila	11.00
52	Хотгуужин чөрх	Histrionicus histrionicus	12.00
53	Мөнгөлөг шунгаахай	Clangula hyemalis	14.00
54	Алаг шунгаач	Bucephala clangula	16.00
55	Тольт монхдой	Melanitta deglandi	24.00
56	Цагаантолгой ямаансүүлт	Oxyura leucocephala	90.00
57	Цахиур бохио	Mergus albellus	10.00
58	Сэвгэр бохио	Mergus serrator	16.00
59	Хумхин бохио	Mergus merganser	20.00

II. Махчин шувуу			
60	Загасч явлаг	Pandion haliaetus	238.00
61	Балч гоорбис	Pernis apivorus	80.00
62	Согсоот гоорбис	Pernis ptilorhyncus	84.00
63	Сохор элээ	Milvus migrans	78.00
64	Саарал хулд	Circus cyaneus	36.00
65	Хээрийн хулд	Circus macrourus	77.00
66	Нугын хулд	Circus pygargus	51.00
67	Алаг хулд	Circus melanoleucus	36.00
68	Намгийн хулд	Circus aeruginosus	40.00
69	Дорнын хулд	Circus spilonotus	42.00
70	Үлэг харцага	Accipiter gentilis	86.00
71	Морин харцага	Accipiter nisus	23.00
72	Үүрсээ харцага	Accipiter badius	22.00
73	Шунгаач харцага	Accipiter gularis	15.00
74	Тарлан сар	Buteo lagopus	70.00
75	Шилийн сар	Buteo hemilasius	84.00
76	Талын сар	Buteo rufinus	74.00
77	Ойн сар	Buteo buteo	67.00
78	Саржуу харцгай	Butastur indicus	22.00
79	Могойч загалай	Circaetus gallicus	140.00
80	Уулын согсоотбүргэд	Spizaetus nipalensis	220.00
81	Бахим бүргэдэй	Hieraaetus pennatus	64.00
82	Харсун бүргэдэй	Hieraaetus fasciatus	58.00
83	Тарважи бүргэд	Aquila nipalensis	253.00
84	Бор бүргэд	Aquila clanga	353.00

85	Хан бүргэд	Aquila heliaca	513.00
86	Цармын бүргэд	Aquila chrysaetos	402.00
87	Усны нөмрөгбүргэд	Haliaeetus leucoryphus	525.00
88	Цагаан сүүл нөмрөг бүргэд	Haliaeetus albicilla	1052.00
89	Ооч ёл	Gypaetus barbatus	540.00
90	Дэлт ёлон	Neophron percnopterus	190.00
91	Нөмрөг тас	Aegypius monachus	972.00
92	Ухаа хажир	Gyps fulvus	540.00
93	Хималайн хажир	Gyps himalayensis	807.00
94	Цагаан шонхор	Falco rusticolus	322.00
95	Идлэг шонхор	Falco cherrug	16000.00
96	Шилийн шонхор	Falco pelegrinoides	66.00
97	Энгэл шонхор	Falco peregrinus	62.00
98	Шууман шонхор	Falco subbuteo	23.00
99	Хайргууна шонхор	Falco columbarius	22.00
100	Турамтай шонхор	Falco vespertinus	20.00
101	Амарын шонхор	Falco amurensis	28.00
102	Зээрд шонхор	Falco naumanni	37.00
103	Начин шонхор	Falco tinnunculus	21.00
III.Бор шувуутан			
235	Монгол хуланжороо	Podoces hendersoni	130.00
236	Наран энхэтбялзуухай	Bombycilla japonica	10.00
237	Наран ажиндар	Megalurus pryeri	10.00
238	Өгөөлэй шулганаа	Saxicola insignis	42.00
239	Бахимхушуу хурагч	Paradoxornis heudei	30.00

240	Бургасны ураншувуу	Remiz pendulinus	7.00
241	Янковскийн хөмрөг	Emberiza jankowskii	10.00
242	Наран хөмрөг	Emberiza yessoensis	11.00

Гурав. Загас **/мян.төгрөгөөр/**

№	ЗАГАСНЫ НЭР	ЛАТИН НЭР	ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ
1	Амарын хилэм	Asipenser schrenckii	1330.00
2	Шивэр хилэм	Asipenser baerii baicalensis	700.00
3	Тул	Hucho taimen	211.00
4	Зэвгэ	Brachymystax lenok	17.00
5	Цагаан загас	Coregonus pidschian	20.00
6	Цагаан хадар	Coregonus chadary	13.00
7	Байгалийн омоль	Coreginus migratorius	19.00
8	Пельд	Coregonus peled	14.00
9	Монгол хадран	Thymallus brevirostris	5.00
10	Хөвсгөл хадран	Thymallus nigrescens	5.00
11	Сибирь хадран	Thymallus arcticus	4.00
12	Амарын хадран	Thymallus grubii	4.00
13	Цурхай	Esox lucius	20.00
14	Амарын цурхай	Esox reicherti	8.00
15	Улаан нүдэн	Rutilus rutilus	5.00
16	Байгалийн сугас	Leuciscus baicalensis	2.00
17	Зүүнгарын сугас	Leuciscus dzungaricus	3.00
18	Бух сугас	Leuciscus idus	9.00
19	Амарын сугас	Leuciscus waleckii	2.00

20	Алтайн сугас	Oreoleuciscus potanini	7.00
21	Нохой сугас	Oreoleuciscus angusticephalus	43.00
22	Улаан живэрт	Pseudaspius leptocephalus	10.00
23	Үхэрдэй	Tinca tinca	11.00
24	Морин загас	Hemibarbus labeo	3.00
25	Толбот морин загас	Hemibarbus maculatus	3.00
26	Цагаан догтор	Erythroculter erythropterus	67.00
27	Улаан далбаат	Chanodichthys mongolicus	12.00
28	Өлгөр цагаан	Culter alburnus	12.00
29	Алтлаг хэлтэг	Carassius carassius	9.00
30	Мөнгөлөг хэлтэг	Carassius gibelio	6.00
31	Булуу цагаан	Cyprinus carpio	19.00
32	Цулбуурт	Parasilurus asotus	9.00
33	Гутаар	Lota lota	13.00
34	Алгана	Perca fluviatilis	5.00
35	Амарын хөөлөнхэй	Pseudorasbora parva	4.00
36	Зантаахай загас	Mesocottus haitej	64.00

УРГАМЛЫГ АХУЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ

Иргэн та элбэг ургамлыг зөвшөөрөлгүй ашиглах эрхтэй бол ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар ашиглаж болно.

Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга, ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар

ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох журам

Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд өгнө.

Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох байгууллага буюу албан тушаалтан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ургамал ашиглах тухай хүсэлтийг тухайн этгээдийн боловсруулсан төсөл, түүний талаархи мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хүсэлт хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгнө.

Нэн ховор, ховор, элбэг ургамалын экологи-эдийн засгийн төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 09 –ний өдрийн А-282 дугаар тушаалын хавсралтаар баталсан. Энэхүү жагсаалтад 595 төрөл, зүйлийн ургамал багтсан байдаг. Ургамлын нөөц ашигласны төлбөр нь экологи эдийн засгийн үнэлгээний ховор ургамал 15-20 хувь элбэг ургамал 5-10 хувь байх ба төлбөрийн хэмжээг Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал энэ хязгаарт багтаан тогтооно.

ОЙН ДАГАЛТ БАЯЛГИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2012 оны 12 дугаар сарын 19 өдрийн
125 дугаар тушаалын хавсралт

№	НЭР, ТӨРӨЛ	АШИГЛАЛТЫН ЗОРИУЛАЛТААР, КГ/ТӨГ		
		Судалгаа, шинжилгээний	Ахуйн	Үйлдвэрлэлийн
1.	Хуш модны самар *Pinussibirica Du tour.*	500	500	800
	ЖИМС			
2.	Монос /мойл/ *PadusasiaticaKom.*	300	300	600
3.	Долоогоно *Crataegus sanguine Pall.*	2700	500	3600
4.	Өндөр улаагана /хад/ *RibesaltissimumTurcz.*	400	300	500
5.	Улаан улаагана /улаалзгана/ *Ribesrubrum L.*	400	300	500
6.	Яшилдуу чацаргана *Hippophaerhamnoides L.*	300	200	400
7.	Нэрс /хөх нэрс/ *Vacciniumuliginosum L.*	400	300	450
8.	Анис, алирс *Vacciniumvitis-idaea L.*	400	300	570
9.	Үхрийн нүд *Ribesnigrum L.*	400	300	600
10.	Өргөст нохойн хошуу *Rosa acicularisLindl.*	300	250	450
11.	Гүзээлзгэнэ *FragariaorientalisLosinsk*	500	300	1000
12.	Далан хальс /чонын элэг/ *Loniceraaltaica*	250	250	460
	МӨӨГ			
13.	Юүлүүр Ташуумаг *ClitocybegibbaKumm.*	300	300	400
14.	Ягаан сархиаг *LactariustorminosusS.F.Gray.*	300	300	400

15.	Шар-ногоон Ур мөөг *Laetiporussulphureus Bond.et Sing.*	300	300	400
16.	Хэврэг чидмэг *Russula emetic S.F.Gray.*	300	300	400
17.	Тосондой *Suillusgrevillei Sing.*	300	300	400
18.	Эгэл далбига *Agaricuscampestris Fr.*	300	300	400
БУСАД				
19.	Хөвд *Sphagnum*	300	150	300
20.	Хусны шүүс /л/	500	500	1000
21.	Нарсны шилмүүс	400	400	800
22.	Давирхай	4000	2000	4000

Тайлбар:

Энэ жагсаалтаар төлбөрийн хэмжээ нь тогтоогдоогүй ойн дагалт баялгийг ашиглах тохиолдолд овог, төрөл, зүйлийн хамаарлаар нь төлбөрийн хэмжээг адилтган тогтоож болно.

НӨХӨН ТӨЛБӨР

Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.

“байгаль орчинд учруулсан хохирол” гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;

“байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны байгаль орчинд учруулсан хохирол, түүнийг арилгах болон цаашид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-эдийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон мөнгөн илэрхийллийг;

Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх (Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйл.)

- Ойн санд учирсан хохирлыг ойн экологи–эдийн засгийн үнэлгээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

• Амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи–эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

• Ургамлын аймагт учирсан хохирлыг тухайн ургамлын экологи–эдийн засгийн үнэлгээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

ХАРИУЦЛАГА

Зөрчил гэж юуг хэлэх вэ?

Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, "Зөрчлийн тухай" Хуулиар шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.

Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан болович түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно.

Зөрчил хамтран үйлдэх:

Зөрчлийг хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АМЬТАН, УРГАМЛЫГ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

(Зөрчлийн тухай хууль Долдугаар бүлэг)

Амьтны тухай хууль зөрчих

1.Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:

Ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн

этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Байгалийн ургамлын тухай хууль зөрчих

Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;

2.элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин

нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ойн тухай хууль зөрчих

Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг: түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зохих зөвшөөрөлтэйгээр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мод, ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Түймрийн аюултай үед:

1.ой, хээрийн бүс нутагт өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлсэн;

2.мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэсэн;

3.шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн, бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаясан;

4.тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

(Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгээс)

Хууль бусаар ан агнах

1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Ой, хээрийн түймэр тавих Гал, шатамхай зүйлтэй болгоомжгүй харьцсаны

улмаас ой, хээрийн түймэр гарч хүний бие махбодид хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; их хэмжээний хохирол учирсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас: 3.1.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; 3.2.их хэмжээний хохирол учирсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх 1.Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Байгалийн тэнцэл алдагдуулах Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ГАЛТ ЗЭВСГИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Галт зэвсэг гэж юу вэ?

• **“галт зэвсэг”** гэж дарины шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг

• **“ангийн буу”** гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд нэг, дайзанд дөрвөөс илүүгүй, өөрөө цэнэглэгдэгч /хагас автомат/ бууны хүхээнд нэг, дайзанд тавaac илүүгүй сумны багтаамжтай галт зэвсгийг;

• **“сум”** гэж галт зэвсэгт зориулагдсан хонгио, бялт, дарин цэнэг, хошуу бүгд нэг биет болж угсрагдсан, эсхүл гол төмөрт хийж буудлага үйлдэх зориулалттай бүрдэл хэсгийг;

• **“галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл”** гэж галт зэвсгээс бусад хийн буу, хавчаахай болон ан агнах, спорт-сургалт, үзмэр, цуглуулгын зориулалттай хэрэгслийг;

Галт зэвсгийн төрөл

- иргэний
- харуул хамгаалалтын
- байлдааны
- хууль сахиулах албаны;

Иргэний зориулалттай галт зэвсэг

• Ан агнах, буудлагын спорт-сургалтаар хичээллэх, үзмэр, цуглуулгын зорилгоор Монгол Улсын иргэний өмчилж, эзэмшиж байгаа галт зэвсгийг **иргэний зориулалттай галт зэвсэг гэнэ.**

• Ан агнах зорилгоор ашиглах галт зэвсэг нь **автоматаар, эсхүл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн хийцийг нь өөрчлөөгүй** галт зэвсэг байх бөгөөд сумны хошуу нь зүрхэвчгүй байна.

Галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, бүртгүүлэх, хадгалах, хязгаарлах



Галт зэвсэг эзэмших

- Энэ хуульд өөрөөр заагаагүй бол 21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан ажилтан, байгаль хамгаалагчид харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллага гэрээний үндсэн дээр албаны үүрэг гүйцэтгэх хугацаанд нь галт зэвсэг эзэмшүүлж болно.

Галт зэвсэг ашиглах

- Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгүүлсэн зориулалтаар нь аюулгүй ажиллагааг ханган ашиглах эрхтэй. Иргэн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа галт зэвсгээ амь бие, эд хөрөнгийг араатан, амьтнаас хамгаалах зорилгоор ашиглаж болно.
- Нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр золбин нохой, муур, гоц халдварт өвчин бүхий мал, амьтныг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгаж болно.
- Нутгийн захиргааны байгууллага, ажиллах журмыг цагдаагийн байгууллагатай хамтран батална.
- Галт зэвсэг өмчлөгч иргэн галт зэвсгээ шаардлага хангасан иргэнд түр хугацаагаар ашиглуулж болно.

Галт зэвсэг бүртгүүлэх

- Иргэний зориулалттай галт зэвсэг худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн ажлын арван өдрийн дотор галт зэвсгээ байнга оршин суугаа газрын нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад бүртгүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

Иргэн

- галт зэвсэг бүртгүүлэхийг хүссэн өргөдөл;
- иргэний үнэмлэхийн хуулбар;
- оршин суугаа газрын баг,

хорооны Засаг даргын тодорхойлолт;

- тухайн иргэний гурван хувь цээж зураг;
- галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаарыг тодорхойлсон баримт бичиг;
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- өмчлөх галт зэвсгийн сумны хонгио, хошууны дээжийг шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээллийн санд бүртгүүлсэн тухай тодорхойлолт;
- галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээ;
- өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас.
- иргэнийг галт зэвсгээр гэмт хэрэг санаатай үйлдэж ял эдэлж байгаагүй талаарх тодорхойлолт

Галт зэвсгийн гэрчилгээ

Галт зэвсгээ бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд галт зэвсгийн гэрчилгээ олгох ба галт зэвсгийн гэрчилгээнд дараах зүйлийг тусгана:

- өмчлөгч иргэний овог, эцэг / эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээдийн тухайд оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, оршин байгаа газрын хаяг;
- галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаар;

- галт зэвсэг өмчлөх зориулалт;
- галт зэвсгийн гол төмрийн голчийн хэмжээ;
- галт зэвсгийн сумны төрөл, зориулалт.

Галт зэвсэг хадгалах

- Галт зэвсэг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн галт зэвсгийн гох, эсхүл замгийг цоожилж, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ /сав/-нд хадгалах ба галт зэвсгээс замгийг салгах боломжтой бол замгийг салгаж хадгална.
- Галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээд галт зэвсгийг зориулалтын тохөөрөмжилсөн өрөөнд, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ /сав/-нд хадгална.
- Иргэн, хуулийн этгээд арав, түүнээс дээш тооны галт зэвсгийг өмчилж, эзэмшиж байгаа бол аюулгүй байдлын шаардлага хангахуйц тусгайлан тоноглосон өрөөнд галт зэвсгийг сумнаас тусад нь зориулалтын шүүгээнд хадгална.
- Галт зэвсгийг хаяж, алдаж үрэгдүүлсэн тохиолдолд энэ талаар мэдсэн даруйдаа цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

Галт зэвсэг, сум худалдаж авах

- Иргэн, хуулийн этгээд борлуулагчаас галт зэвсэг худалдаж авах тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад бичгээр гаргана.
- Цагдаагийн байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор шаардлагыг хангасан иргэнд иргэний үнэмлэх, өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудсыг үндэслэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгоно.
- Борлуулагч галт зэвсэг эзэмших эрхтэй иргэн, хуулийн этгээдэд сум худалдах бөгөөд иргэн, хуулийн этгээдийн худалдан авсан сумны талаарх мэдээллийг цагдаагийн байгууллагад ажлын гурван өдрийн дотор хүргүүлнэ.

Галт зэвсэг худалдах, өвлөх, бэлэглэх

- Иргэн, хуулийн этгээд өөрийн өмчид байгаа галт зэвсгийг хуульд заасан шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдэд худалдаж болно.
- Иргэн, хуулийн этгээд галт зэвсгийг худалдсан талаар тухайн галт зэвсгийг бүртгэлд авсан цагдаагийн байгууллагад ажлын арван өдрийн дотор мэдэгдэж, тэмдэглэл хийлгэн бүртгэлээс хасуулна.
- Иргэн, хуулийн этгээд өөрийн сайн дураар галт зэвсэг, сумыг цагдаагийн байгууллагад шилжүүлж болно.

Хууль бусаар зэвсэг эзэмших
(Зөрчлийн тухай хууль. 5.6 зүйлээс)

1.Хууль бусаар тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, агсамжийг биедээ авч явсан, хадгалсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Иргэний, эсхүл харуул хамгаалалтын зориулалттайгаас өөр

төрлийн галт зэвсэг өмчилсөн, эсхүл эзэмшсэн бол тухайн галт зэвсгийг хурааж хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд зааснаас өөр зориулалтаар галт зэвсэг өмчилсөн бол тухайн галт зэвсгийг хурааж хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуульд заасны дагуу сургалтад сууж гэрчилгээ аваагүй, хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн галт зэвсгийг хурааж хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Галт зэвсэг бүртгүүлэх, хадгалах, ашиглах, эзэмших, худалдан авах журам зөрчсөн бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Тусгай зөвшөөрөлгүйгээр галт зэвсэг, сум импортолсон, худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн галт зэвсэг, сумыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Галт зэвсэг, сумыг худалдан авагч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хуульд заасны дагуу цахим бүртгэлд хадгалаагүй бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Галт зэвсэг авч явах, эсхүл тээвэрлэх журам зөрчсөн, эсхүл хуульд заасан хугацаанд галт зэвсгийн тооллогод хамрагдаагүй бол хүнийг дөчин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Энэхүү гарын авлагыг Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн хэрэгжүүлж буй "Хуулийн хэрэгжилтийг сайжруулснаар зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах нь" төслийн захиалгаар "МОНГОЛЫН ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨЛ" ТББ нд боловсруулав.

Чингэлтэй дүүрэг, IV хороо, Самбуугийн гудамж 13/2
Глобал бизнэс төв 403 тоот
Утас: 70009501, 88119501
И-мэйл: munkhzorig@forest.mn; www.forest.mn

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Монре Импексийн байр 302
Утас: 77111138